ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 05 дугаар сарын 28 №08 Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр 14:00 цагт ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн танхимд (1-203) 76,2 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд:

Хөтөлбөрийн ерөнхий хорооны дарга

1. Н.Эрдэнэхүү — Сургалт, оюутны асуудал эрхэлсэн проректор

Нарийн бичгийн дарга

2. М.Эрдэнэтуяа — Сургалтын бодлого, зохицуулалтын албаны дарга

Гишүүд

3. И.Цэрэн-Онолт — АТС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч
4. Ж.Алтанцэцэг — БАС-ийн барилгын инженерчлэлийн тэнхимийн дэд профессор
5. Ц.Энхбаатар — ГХС-ийн захирал
6. А.Болормаа — ГХС-ийн сургалт чанарын албаны дарга
7. Г.Өлзийсайхан — ГУУС-ийн сургалт, чанарын албаны дарга
8. М.Банзрагч — МС-ийн сургалт, чанарын албаны дарга
9. П.Ууганбаяр — МХТС-ийн сургалт, чанарын албаны дарга
10. Д.Ариунболор — НБХ-ийн профессор
11. С.Туяа — НХС-ийн сургалт, чанарын албаны дарга
12. Б.Майзул — ХХҮДС-ийн биотехнологи, шим судлалын тэнхимийн профессор
13. Ц.Балжинням — ХШУС-ийн сургалт, чанарын албаны дарга
14. Ч.Алдармаа — ХШУС-ийн физикийн тэнхимийн профессор
15. Д.Болор-Эрдэнэ — ШУТИС-ийн харьяа ЭЦДС-ийн сургалтын албаны дарга
16. Г.Ариунтөгс — Сургалтын бодлого, зохицуулалтын албаны ахлах мэргэжилтэн

нар оролцов.

Хэлэлцэх асуудлууд:

1. МИТС-тай хамтран 1+3 хэлбэрээр хэрэгжүүлж буй “Механик инженерчлэл” бакалаврын хөтөлбөрийг 2+2 хэлбэрээр хэрэгжүүлэх тухай (ЭЦИС)
2. “Үйлдвэрлэлийн менежмент” бакалаврын хөтөлбөрөөр МС-тай хамтарсан (2+2) хөтөлбөр хэрэгжүүлэх тухай (ЭЦИС)
3. “Нягтлан бодох бүртгэл” бакалаврын хөтөлбөрийг ӨмДТС-тай хамтын ажиллагааны хүрээнд 1+3 хэлбэрээр хэрэгжүүлэх тухай (ЭЦИС)
4. МС-ийн “Бизнес шинжлэл, загварчлал” бакалаврын хөтөлбөрийг хамтын ажиллагааны хүрээнд дамжуулан хэрэгжүүлэх тухай (ЭЦИС)
5. МС-ийн “Менежмент” бакалаврын хөтөлбөрийг хамтын ажиллагааны хүрээнд дамжуулан хэрэгжүүлэх тухай (ЭЦИС)
6. МС-тай хамтран 2+2 хэлбэрээр хэрэгжүүлж буй “Санхүү, банк” бакалаврын хөтөлбөрийг хамтын ажиллагааны хүрээнд дамжуулан хэрэгжүүлэх тухай (ЭЦИС)
7. ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага
8. ШУТИС-ийн ахисан түвшний хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. ШУТИС-ийн харьяа ЭЦДС-иас хэлэлцүүлсэн асуудлуудыг дараах байдлаар шийдвэрлэв.
    - МИТС-тай хамтран (1+3) хэлбэрээр хэрэгжүүлж буй “Механик инженерчлэл” бакалаврын хөтөлбөрийг (2+2) хэлбэрээр хэрэгжүүлэх асуудлыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.
    - “Үйлдвэрлэлийн менежмент” бакалаврын хөтөлбөрөөр МС-тай хамтарсан (2+2) хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.
    - “Нягтлан бодох бүртгэл” бакалаврын хөтөлбөрийг ӨмДТС-тай хамтын ажиллагааны хүрээнд (1+3) хэлбэрээр хэрэгжүүлэх асуудлыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.
    - МС-ийн “Менежмент” бакалаврын хөтөлбөрийг хамтын ажиллагааны хүрээнд дамжуулан хэрэгжүүлэх асуудлыг гишүүдийн 90 хувийн саналаар дэмжив.
    - МС-тай хамтран (2+2) хэлбэрээр хэрэгжүүлж буй “Санхүү, банк” бакалаврын хөтөлбөрийг хамтын ажиллагааны хүрээнд дамжуулан хэрэгжүүлэх асуудлыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.
    - МС-ийн “Бизнес шинжлэл, загварчлал” бакалаврын хөтөлбөрийг хамтын ажиллагааны хүрээнд дамжуулан хэрэгжүүлэх тухай саналыг түр түдгэлзүүлэв.
2. “ШУТИС-ийн ахисан түвшний хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын төслийг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн саналын дагуу сайжруулалт хийн, баталгаажуулах саналыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ. Дараах тухайлсан агуулга дээр санал хураав.
    - Хүснэгт 4.17. Нийтлэг мэргэжлийн суурь хичээлийн төлөвлөлтөд 3 кредиттэй 3 хичээл байхаар төлөвлөх (Судалгааны арга зүй, Академик бичиглэл ба харилцааны ур чадвар, Судалгааны ёс зүй ба оюуны өмч);
    - 4.5.24-т “Хөтөлбөрөөс хамаарсан суурь хичээлийг тодорхойлох, төлөвлөх үйл ажиллагааг бүрэлдэхүүн, салбар сургуулийн холбогдох хөтөлбөрийн дэд хороод хамтран хэрэгжүүлнэ” гэж тусгах;
3. “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын төсөлд хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн санал зөвлөмжийн дагуу мэргэжлийн суурь агуулгад заавал эзэмших ур чадвар олгох механик, зураг зүйн гэх мэт хичээлийг холбогдох бүрэлдэхүүн сургуулиас санал авч, тухайн чиглэлд тусган баталгаажуулахыг дэмжлээ.

4. “Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 7.14 заалтын хүрээнд “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын 2.5.1.17, 2.5.1.18 заалтын заавал судлах дараах тухайлсан агуулга дээр санал хурааж, 2026-2027 оны хичээлийн жилээс мөрдөхөөр шийдвэрлэв.
    - Хүмүүнлэгийн ухаан агуулгад “Монголын түүх, соёл; Монгол хэл, бичиг, найруулга зүйн чиглэлийн суралцахуйн үр дүнг эзэмшүүлэх 6-аас доошгүй багц цагийн хичээлийг сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгана” гэж заасан тул “Монголын түүх” хичээлийг бүх хөтөлбөрт төлөвлөх;
    - Салбар чиглэлийн ерөнхий суурийн хичээл агуулгад “Сонгосон мэргэжлийн онцлог, ажлын байрны шаардлага, хөгжлийн чиг хандлага, давуу талыг тайлбарлах, мэргэжлийн чиглэлийн суурь мэдлэг, чадварыг асуудал шийдвэрлэхэд хэрэглэх, хувь хүний, харилцааны үндсэн мэдлэг, чадварыг

мэргэжлийн хүрээнд хэрэглэх” гэж заасны дагуу хичээлийн агуулгыг өргөтгөх саналын дагуу “Мэргэжлийн удиртгал” хичээлийг 2 кредитээр төлөвлөх;

5. **Бусад асуудал:** 2026 оны элсэлтийн үйл ажиллагаа зохион байгуулахтай холбоотой зарим шинээр нээх саналтай сургалтын хөтөлбөрүүдийг зарлах тухай асуудлыг дараах байдлаар шийдвэрлэв.

   УМИ-ийн шийдвэр гарсан дараах үндсэн хөтөлбөрүүдээр элсэлт зарлах:

   - “Хэрэглээний математик” бакалавр
   - “Эрчим хүчний ухаалаг сүлжээ ба систем” бакалавр

   Гадаадын их сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан дараах хөтөлбөрүүдээр элсэлт зарлах:

   - “Гадаад хэлний орчуулга”, “Нийгмийн ажил”, “Интерьер дизайн” БНСУ-ийн Чусон их сургуультай хамтарсан;
   - “Электроникийн инженерчлэл”, “Материал судлал, инженерчлэл” БНХАУ-ын Шанхайн Зам тээврийн их сургуультай хамтарсан;
   - “Хэрэглээний математик” Япон улсын Кумамото их сургуультай хамтарсан;
   - “Хөргөлтийн технологи ба кондиционерийн систем” БНХАУ-ын Хойд Хятадын цахилгаан эрчим хүчний их сургуультай хамтарсан;
   - “Нүүрсний боловсруулалтын технологи” БНХАУ-ын Уул уурхайн технологийн их сургуультай хамтарсан.